

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН  
СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН  
ТООЦООНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН

# СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

## НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл /цаашид “Хуулийн төсөл” гэх/ -ийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Энэхүү үнэлгээний зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад оршино.

Аргачлалын ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог.

Энэхүү аргачлалд зааснаар хуулийн этгээдийн зардлыг тооцоходоо хууль тогтоомжоор төрийн байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах мөнгөн зардлыг, иргэнд үүсэх зардлыг тооцоходоо хууль тогтоомжоор иргэнд хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарцуулах цаг хугацааг тус тус тооцон гаргана.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- > Хуулийн этгээд, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;<sup>1</sup>
- > Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;<sup>2</sup>
- > Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;<sup>3</sup>
- > Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах<sup>4</sup>

Хуулийн төслийн зохицуулалтаас харахад согтууруулах ундааны зохистой хэрэглээ, худалдаа, үйлчилгээг бий болгоход чиглэсэн энэ чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч нарт илүүтэйгээр үүрэг хүлээлгэсэн агуулгатай зохицуулалт хуулийн

<sup>1</sup>Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.3, 4.3 дахь зохицуулалт.

<sup>2</sup> Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.4.4, 4.4 дэх зохицуулалт.

<sup>3</sup>Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 4.4.3.1 дэх зохицуулалт.

<sup>4</sup>Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.1, 4.1 дэх зохицуулалт.

төслийн дийлэнхи хэсгийг эзэлж байна. Төрийн байгууллагын хувьд тэдгээрээс гүйцэтгэх үүрэгт ямар нэгэн зарчмын шинжтэй өөрчлөлт орсон зүйлгүйгээс гадна одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой харьцуулахад шинээр үүрэг хүлээлгэсэн зарчмын шинжтэй зохицуулалт байхгүй байна.

3  
-оОо-

## **ХОЁР.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ**

Хуулийн төслийн энэхүү хувилбар нь нийт 7 бүлэг, 45 зүйлтэйгээр боловсруулагдсан байх бөгөөд хуулийн төслийн бүтцийг авч үзвэл:

1. Нийтлэг үндэслэл
2. Согтууруулах ундааны үйлдвэрлэл
3. Согтууруулах ундааны экспорт, импорт
4. Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ
5. Согтууруулах ундааны хэрэглээ
6. Архидан согтуурахтай тэмцэх
7. Шилжилтийн үеийн зохицуулалт болон бусад зүйл гэсэн бүлэгтэй байна.

Хуулийн төсөлд заасан зохицуулалтуудад дүн шинжилгээ хийж үзэхэд согтууруулах ундааны үйлдвэрлэл болон экспорт, импортын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд заасан зохицуулалттай ижил буюу дээрхи төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдүүдэд хуулийн төсөл батлагдсанаар нэмэлт ачаалал, зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна гэж үзэхээр байна.

Аргачлалын 2.1, 2.2-т зааснаар хуулийн этгээдийн зардлыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

1. хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. зардлыг тооцох;
3. тоон үзүүлэлтийг тооцох;
4. нийт зардлын дүнг тооцож гаргах;
5. хялбарчлах боломжийг шалгах;
6. нэмэлт зардлыг тооцох.

**Нэгдүгээр үе шатны хүрээнд:** Аргачлалын 2.3-т зааснаар “гүйцэтгэх үүрэг” гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ гэж заасан.

Хуулийн төсөлд зааснаар төрийн байгууллагад зардал үүсгэх шинжтэй үүрэг болгосон нэлээдгүй заалтууд байгаа бөгөөд эдгээрийг согтууруулах ундааны эргэлтэд хамаарах үйл ажиллагаа бүрээр нь багцлан дараахь

байдлаар авч үзэж болохоор байна.

### **А.Согтууруулах удаа үйлдвэрлэх**

1.1 Хуулийн төслийн 6 дугаар зүйл:

**6 дугаар зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг**

### **Б.Согтууруулах ундаа худалдах**

Байхгүй.

### **В.Согтууруулах ундаагаар үйлчлэх**

1.2 Хуулийн төслийн 27 дугаар зүйл

<b>Хамаарах зүйл</b>	<b>Гүйцэтгэх арга хэмжээ</b>	<b>Үйл ажиллагаа, үе шат</b>	<b>Зарцуулах хугацаа</b>
27 дугаар зүйл	27.1.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтан нь согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтад хамрагдсан байна.	Сургалтын талаар мэдээлэл цуглуулах	30
	27.3.Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтыг аймаг, нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан нэгжээс магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд гүйцэтгэх бөгөөд төлбөрийн жишгийг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно. Сургалтын үргэлжлэх нийт хугацаа 5 цагаас ихгүй, 3 цагаас багагүй байна.	Сургалтад хамрагдах	240
<b>Нийт</b>			<b>270</b>

### **Г.Согтууруулах ундаа импортлох**

1.5. Хуулийн төслийн 15 дугаар зүйл

15.1.Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн

техникийн зохицуулалтыг эрүүл мэндийн болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

15.2.Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлт нь согтууруулах ундаанд тавигдах үндэсний стандарт болон чанар, аюулгүй байдлын үзүүлэлтээс доошгүй байна.

**Хоёрдугаар үе шатны хүрээнд:** Зардлыг тооцох бөгөөд зардлыг тооцохдоо үүрэг тус бүрийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараахь журмын дагуу зохион байгуулна:

- 2.1. Зардлыг тооцохын тулд ажилтны ажлын хөлс, мэдээлэл бэлтгэн гаргахтай холбогдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн хугацааг нэг бүрчлэн тодорхойлно.
- 2.2. Ажлын хөлсийг тухайн салбарын цалин хөлсний дундаж дүнгээр тооцох бөгөөд дараахь томъёог ашиглана.

***Ажлын хөлс=Үндсэн цалин+Ажиллах хугацаа***

***Тайлбар: Нэг сараар тооцно.***

- 2.3. Ажлын хөлсийг тооцохдоо хуулийн этгээдийн төрөл, тухайн үйл ажиллагаанд ердийн болон нарийн мэргэжлийн ур чадвар шаардлагатай эсэхийг харгалзан үзнэ
- 2.4. Зардлыг тооцохдоо тухайн үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагаа нэг бүрийг ямар хугацаанд гүйцэтгэхийг дунджаар тооцож гаргах хэрэгтэй бөгөөд тухайн үйл ажиллагааг ямар хугацаанд хийж гүйцэтгэхийг тогтоосон загвар, стандарт (хүснэгт 1) байдаг бол түүнийг ашиглаж болно.
- 2.5. Аргачлалын 2.4.4-т заасан загвар байхгүй тохиолдолд тухайн үүрэгтэй ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлээс **судалгаа авах, ярилцлага, хэлэлцүүлэг хийх зэрэг аргаар** шаардлагатай мэдээллийг цуглуулж, зарцуулагдах хугацааг тодорхойлно.
- 2.6. Зардлыг тооцож гаргахдаа үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг ажлын хөлсөөр үржүүлэх бөгөөд дараахь томъёог ашиглана:

***Зардал (Үйл ажиллагаа тус бүрийн)=Хугацаа\*Ажлын хөлс***

Зардлыг тооцох энэ үе шатанд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд үүсэх зардлыг

тооцохдоо тухайн 1 жилд манай улсад үйлдвэрлэсэн болон импортолсон тодорхой төрлийн согтууруулах ундааны нийт дүнг авч үзэх бөгөөд энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн тоонд харьцуулж дундажлаж тооцсон болно.

Нэгдүгээр үе шатны хүрээнд тодорхойлсон үүргүүдийг хэрэгжүүлэх талаар тогтсон жишиг, тоо баримт байхгүй тул тэдгээр үүргүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа тус бүрийг ижил төстэй үйл ажиллагаатай харьцуулж, үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэх хугацааг дараахь байдлаар тогтоолоо:

#### А.Согтууруулах ундаа үйлдвэрлэх

Хамаарах зүйл	Гүйцэтгэх арга хэмжээ	Үйл ажиллагаа, үе шат	Зарцуулах хугацаа /мин/
6 дугаар зүйл	6.1.1.согтууруулах ундааны үйлдвэрийн төслийн баримт бичиг;	Зорилгоо тодорхойлох	240
		Судалгаа хийх	4800
		Шинжилгээ	2400
		Тодорхойлох	2400
		Төлөвлөх	1200
		Илэрхийлэх, дэмжүүлэх	1200
		Эцэслэн боловсруулах	1200
	6.1.2.урьд өмнө үйл ажиллагаа эрхэлж байсан бол аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;	Дүгнэх, шаардлагатай засвар оруулах	480
		Аудитын байгууллагад хүргэх	60
		Шаардлагатай мэдээлэл гаргаж өгөх, тайлбар гаргаж өгөх	480
	6.1.3.үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, тэдгээрийн чанар, стандарт, өмчлөлийн талаархи мэдээлэл;	Тайланг авах	60
		Шаардлагатай мэдээллийг цуглуулах	180
	6.1.4.үйлдвэрлэх согтууруулах ундааны нэр, төрөл, хэмжээ, үйлдвэрлэлийн хүчин чадлыг тодорхойлсон баримт бичиг;	Төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээлэл, лавлагаа гаргуулах, тэдгээрийг цуглуулах, бэлтгэх	1200
		Мэдээлэл цуглуулах	480
		Тооцоолон бодох	180
		Эцэслэн тодорхойлох	60

	6.1.5. үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хатуулгыг бүртгэх, мэдээлэх тоног төхөөрөмж суурилуулах, түүнийг нэгдсэн сүлжээнд холбох тооцоолол;	Мэдээлэл цуглуулах	480
		Тооцоолон бодох	180
		Эцэслэн тодорхойлох	60
	6.1.6. татварын албаны тодорхойлолт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хатуулгыг бүртгэх, мэдээлэх тоног төхөөрөмжийн талаархи санал дүгнэлт.	Шаардлагатай төрийн байгууллага, албан тушаалтныг тодорхойлох, уулзалт хийх,	180
		Газар дээр нь танилцуулах, үзүүлэх	360
		Шаардлагатай баримт бичгийг авах	180
	6.1.7. энэ хуулийн 6.1.1-д заасан төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, мэргэжлийн хүний нөөцийн талаарх мэдээлэл.	Мэдээлэл цуглуулах	480
		Тооцоолон бодох	180
		Эцэслэн тодорхойлох	60
8 дугаар зүйл	8.2. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах бол түүний хугацааг дуусахаас гурван сар, түүнээс багагүй хугацааны өмнө хүсэлтээ гаргах бөгөөд уг хугацааг баримтлаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.	Хавсаргах шаардлагатай баримт бичгийг бэлтгэх	240
11 дүгээр зүйл	11.3. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг тоо, хэмжээ, хатуулгийг бүртгэж, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол мэдээлэх үүрэгтэй.	Бүртгэх	60
		Мэдээлэх	120
Нийт			<b>19 380</b>

## Б.Согтууруулах ундаагаар худалдах

Байхгүй

## В.Согтууруулах ундаагаар үйлчлэх

Хамаарах зүйл	Гүйцэтгэх арга хэмжээ	Үйл ажиллагаа, үе шат	Зарцуулах хугацаа
27 дугаар зүйл	27.1.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтан нь согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтад хамрагдсан байна.	Сургалтын талаар мэдээлэл цуглуулах	30
	27.3.Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтыг аймаг, нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан нэгжээс магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд гүйцэтгэх бөгөөд төлбөрийн жишгийг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно. Сургалтын үргэлжлэх нийт хугацаа 5 цагаас ихгүй, 3 цагаас багагүй байна.	Сургалтад хамрагдах	240
Нийт			270

## Г.Согтууруулах ундаа импортлох

Хамаарах зүйл	Гүйцэтгэх арга хэмжээ	Үйл ажиллагаа, үе шат	Зарцуулах хугацаа /мин/
	15.1.Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг эрүүл мэндийн болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.	Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах	20
		Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, согтууруулах ундаа чанар, үзүүлэлт, худалдах- худалдан авах гэрээ зэрэг шаардлагатай баримт бичгийг хуулбарлах, бэлтгэх	60



15 дугаар зүйл	15.2.Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлт нь согтууруулах ундаанд тавигдах үндэсний стандарт болон чанар, аюулгүй байдлын үзүүлэлтээс доошгүй байна.	Импортлох ундааны нэр төрөл, тоо хэмжээг тооцоолох, тодорхойлох	60
		Импортлох согтууруулах ундааны дээжийг хилийн гаалийн эрүүл ахуйн хяналт шалгалт хийлгүүлэх, баталгаажуулсан баримт дүгнэлт гаргуулах	960
		Импортлох согтууруулах ундаа нь Улсын техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангасан, чанар аюулгүй байдлыг баталгаажуулсан, тохирлын гэрчилгээ авсан тухай Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвийн дүгнэлт, тодорхойлолт авах	960
		Импортлох согтууруулах ундааны дээжийг мэргэжлийн хяналтын байгууллагаар урьдчилан шинжлүүлж, эрүүл ахуйн нөхцөл, эрүүл мэндийн дүгнэлтийг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас согтууруулах ундааны төрөл тус бүрээр баримт гаргуулах	960
		Согтууруулах ундаа хадгалах болон худалдах байрны талаарх мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт авах	960
		Татварын албаны санал тодорхойлолт авах	960
<b>Нийт</b>			<b>4940</b>

Дээрхи чиг үүргийг хэрэгжүүлэх талаар тогтсон жишиг, тоо баримт байхгүй тул үйл ажиллагаа тус бүрд зарцуулах хугацааг тооцохдоо одоо хэрэгжүүлж байгаа практик болон төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн ажилбарт ажлын байрны зураг авалтын үр дүнд гаргасан хугацаан дээр үндэслэн тэдгээрийн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцсон болно.

**А.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмших хуулийн этгээд мэдээлэх үүрэгтэй холбогдуулан нийт 19380 минутын зардал гаргахаар нийт зарцуулахаар гарч байна.**

**Үүнээс тогтмол шинжтэй үүрэг буюу хуулийн төслийн 8 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлэхэд 420 минут, 11 дүгээр зүйлд заасан үүргийг биелүүлэхэд 180 минут зарцуулахаар байна**

**Б.Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд шинээр зардал үүсэхгүй.**

**В.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд 270 минутын зардал гарахаар**

**Г.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл эзэмших хуулийн этгээд 4940 минутын зардал гаргахаар тооцоо тус тус гарсан байна.**

Энэ үе шатанд **ажлын хөлсийг тооцоолон гаргахдаа** ажилтанд олгох сарын үндсэн цалин, сард ажиллах хугацааг тодорхойлсны үндсэн дээр дараахь томъёогоор гаргав. Хуулийн төсөлд заасан хуулийн этгээдийн үүрэг нь бүхий л төрлийн уйл ажиллагаа явуулж байгаа, бүхий л салбарын хуулийн этгээдуудэд хамаарах тул сарын цалинг дундажлан тооцоолов.

### **САРЫН ЦАЛИН / АЖИЛЛАХ ХУГАЦАА = АЖЛЫН ХӨЛС**

Төрийн бус байгууллагын албан хаагчийн нэг сарын дундаж цалинг албан ёсоор дундажлан гаргасан мэдээлэл байхгүй байсан бөгөөд 2011 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Олон Улсын хөдөлмөрийн байгууллага, БНСУ-ын Засгийн газрын түншлэлийн хөтөлбөрөөс хамтран гаргасан Цалин хөлсний бүтцийн туршилтын судалгааны бодлогын шинжилгээний тайланд ТББ-ын удирдах ажилтны цалин хөлсийг өндөр, бусад ажилтнуудын цалин хөлсийг бага байна гэж үзсэн бөгөөд ерөнхийд нь хувьчлан тооцож нарийвчлан тодорхой гаргаагүй байна. Иймээс дунджаар албан хаагчийн сарын цалинг Үндэсний статистикийн хорооноос гаргасан дунджаар буюу 953 000 төгрөгөөр тооцоолов.

Харин ажиллах хугацааг тооцоходоо Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан ажлын цагаар тооцоолон долоо хоногт ажлын цаг нь 40 цаг, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг гэж тооцоход нийт нэр сард 10 560 минут ногдож байна.

$$953.000 / 22 \text{ ажлын өдөр} / 8 \text{ цаг} / 60 \text{ минут} = 90.2 \text{ төгрөг}$$

$$\text{АЖЛЫН ХӨЛС} * \text{ХУГАЦАА} = \text{ЗАРДАЛ}$$

**А.Согтууруулах ундаа үйлдвэрлэх**

$$90.2\text{төг} * 19380 \text{ мин} = 1\,748\,076 \text{ төгрөг /нийт/}$$

$$90.2\text{төг} * 420 \text{ мин} = 37\,884 \text{ төгрөг /8 дугаар зүйл/}$$

$$90.2\text{төг} * 180 \text{ мин} = 16\,236 \text{ төгрөг /11 дүгээр зүйл/}$$

## **Б.Согтууруулах ундаа худалдах**

**Байхгүй.**

## **В.Согтууруулах ундаагаар үйлчлэх**

**90.2 төг \* 270 мин = 24 534 төгрөг**

## **Г.Согтууруулах ундаа импортлох**

**90.2 төг \* 4940 мин = 445 588 төгрөг**

**Гуравдугаар үе шатны хүрээнд: Аргачлалын 2.5 дахь хэсэгт заасны дагуу тоон үзүүлэлтийг тооцох үе шатанд тухайн үүргийг холбогдох хуулийн этгээд хэдэн удаа хэрэгжүүлэхийг хуанлийн нэгжилээр тооцож гаргах шаардлагатай.**

Үүний тулд Монгол Улсад хуулийн төсөлд заасан чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн тоо, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл бүрийг нарийвчлан гаргаж тооцоолсон болно.

## **ТОХИОЛДЛЫН ТОО \* ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ**

Тохиолдлын тоо гэдэг нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээд гүйцэтгэх вэ гэдэгтөө бөгөөд харин давтамж нь нэгдүгээр шатны хүрээнд тодорхойлсон үүргийг нэг жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэсэн тоо болно.

### **А.Согтууруулах ундаа үйлдвэрлэх**

Хүнс, хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны албан ёсны цахим хуудаснаас авсан тооноос харахад 2019 оны байдлаар спиртийн 8, шар айрагны 17, архины 35, дарсны 8 буюу согтууруулах ундаа үйлдвэрлэх нийт 68 тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр нь нэгэнт тусгай зөвшөөрлөө авсан үйл ажиллагаа явуулж байгаа тул хуулийн төслийн 6 дугаар зүйлд заасан зардал тэдгээрийн хувьд үүсэхгүй, үүсэх үндэслэлгүй юм.

Харин хуулийн төслийн 8 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл сунгахтай холбоотой асуудал нь 5 жилд нэг удаа сунгахаар тооцсон болно.

Дээрхи тооноос харахад нийт үүрэг хүлээх хуулийн этгээдийн тоог 68 гэж үзэж, харин тохиолдлын тоог 0,5 гэж тооцооллоо.

$$68 \text{ хуулийн этгээд} * 0.5 \text{ удаа} = 34$$

Хуулийн төслийн 12 дугаар зүйлд заасан үүргийг сар тутам гүйцэтгэх бөгөөд

$$68 \text{ хуулийн этгээд} * 12 \text{ удаа} = 816$$

**Б.Согтууруулах ундаа худалдах**

**Байхгүй.**

**В.Согтууруулах ундаагаар үйлчлэх**

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон хөдөө орон нутаг, аймгуудаас цуглуулсан мэдээллээс харахад ойролцоогоор улсын хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий 3300 орчим хуулийн этгээд байгаа бөгөөд тэдгээрт дунджаар 2 ажилтан ажилладаг гэж тооцоолов.

$$3300 \text{ хуулийн этгээд} * 2 \text{ ажилтан} = 6$$

**600 Г.Согтууруулах ундаа импортлох**

Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж 150 орчим байна гэж тооцоолоход

$$150 \text{ хуулийн этгээд} * 1 \text{ удаа} = 150$$

**Дөрөвдүгээр үе шатны хүрээнд:** Нийт зардлын дүнг тооцон гаргах бөгөөд өмнөх шатанд тооцож гаргасан үйл ажиллагаа нэг бүрийн зардлыг тоон үзүүлэлтээрээ үржүүлнэ.

**НЭГ БҮРИЙН ЗАРДАЛ \* ТООН ҮЗҮҮЛЭЛТ = ЗАРДАЛ**

**А.Согтууруулах ундаа үйлдвэрлэх**

$$37\,884 \text{ төгрөг} * 34 = 1\,288\,056 \text{ төгрөг}$$

$$16\,236 \text{ төгрөг} * 816 = 13\,248\,576 \text{ төгрөг}$$

**Б.Согтууруулах ундаа худалдах**

**Байхгүй**

**В.Согтууруулах ундаагаар үйлчлэх**

$$24\,534 \text{ төгрөг} * 6600 = 161\,924\,400 \text{ төгрөг}$$

**Г.Согтууруулах ундаа импортлох**

**445 8 төгрөг \* 150 = 66 838 200 төгрөг**

**НИЙТ = 243 299 232 ТӨГРӨГИЙН ЗАРДАЛ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХЭЭР БАЙГАА НЬ ЭНЭ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ 10 000 ОРЧИМ АЖ АХУЙН НЭГЖИД ХУВААХАД ДУНДЖААР НЭГ ХУУЛИЙН ЭТГЭЭД 24 000 ТӨГРӨГИЙН ЗАРДАЛ ГАРГАХААР БАЙНА.**

**Тавдугаар үе шатны хүрээнд:** Хувилбарыг нягтлан хялбарчлах боломжийг шалгах бөгөөд өмнөх үе шатанд зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана.

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл нь өөрийн тодорхойлсон үзэл баримтлалд нийцсэн зохицуулалттай буюу хариуцлагатай үйлчилгээний стандартыг тогтоох, эрэлтийг бууруулах зорилгын хүрээнд боловсруулагдсан байна.

Хуулийн төслийг боловсруулахад гадаад улсуудын хууль тогтоомжийг судалж, үзэл баримтлалд тусгагдсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн үр дүнтэй гэж үзсэн бүхий л зохицуулалтыг тусгасан бол хуулийн этгээдэд хүлээлгэсэн үүргийг хуулийн төсөлд тусгаснаас өөрчлөх буюу хуулийн этгээдийн үүргийн цар хүрээг хумих боломжгүй байна. Харин дээр дурдсан тоо нь Монгол Улсад энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд бүрийн тоо, болон тэдгээрт хүлээлгэсэн үүргийг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг хамгийн их байх хэмжээгээр нь тооцоолсон тул үнэн хэрэг дээрээ хуулийн этгээдийн хуулийг хэрэгжүүлэх зардал дээр дурдсанаас бага байх үндэслэлтэй байна.

Түүнчлэн хуулийн төсөлд заасан хуулийн этгээдэд хүлээлгэсэн, зардлыг нь тооцсон зарим үүрэг нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд нэгэнт заагдсан үүрэг бөгөөд хуулийн үйлчлэлд хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй байна.

Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй бөгөөд энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд бүр хамрагдах шаардлагатай.

Аргачлалын 2.7-д заасан асуултуудын дагуу хуулийн этгээдийн зардлыг багасгах боломж байгаа эсэхийг дараахь байдлаар тодорхойллоо. Үүнд:

2.7.1. хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх;

**Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй бөгөөд энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд бүр хамрагдах шаардлагатай**

2.7.1. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

**Хуулийн төсөлд мэдээлэл хүргүүлэх давтамжийг хамгийн бага байх байдлаар тусгасан тул давтамжийг багасгах боломжгүй байна.**

2.7.3. мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

**Мэдээллийн агуулгыг багасгах боломжтой юм. Тухайлбал, согтууруулах ундааны импортын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг баримтыг хуульд тодорхой заах, тэдгээрийн хязгаар, хүрээг тодорхой болгосноор хуулийн этгээдэд үүсэх зардлыг хэмнэх боломжтой байна.**

2.7.4. шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх;

**Үүргийг ямар нэгэн байдлаар нэгтгэх боломжгүй гэж үзэж байна.**

2.7.5. мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

**Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотойгоор зайлшгүй хүргүүлэх шаардлагатай мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлсэн тохиолдолд мөн хуулийн этгээдэд үүсэх зардлыг хэмнэх бүрэн боломжтой байна.**

2.7.6. мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

**Мэдээллийг хүлээн авах байгууллагын тоог багасгах боломжгүй.**

2.7.7. нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх гэх мэт.

**Боломжгүй байна.**

**Зургадугаар үе шатны хүрээнд:** Нэмэлт зардлыг тооцно. Энэхүү үе шатанд шаардлагатай бол үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч болох нэмэлт зардлыг тооцох бөгөөд ямар нэгэн арга, томъёо байхгүй энгийн математик тооцооны аргыг ашиглан тооцоолдог.

Хуулийн төслийг дагалдан гарах Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт

“21<sup>2</sup>.2. Архидан согтуурах болон донтох өвчний хор уршигтай тэмцэх сангийн хөрөнгө энэ хуулийн 6.1.2, 6.1.3-т заасан эх үүсвэр болон **спиртээс бусад** согтууруулах ундааны үйлдвэрлэл, спирт, согтууруулах ундааны импортын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлсэн хөрөнгөөс бүрдэнэ.

21<sup>2</sup>.3. Энэ хуулийн 21<sup>2</sup>.2-т заасан хуулийн этгээдээс татаж бүрдүүлэх хөрөнгийг согтууруулах ундааны 1 литр тутамд дараах байдлаар тооцон онцгой албан татвартай хамт төлүүлж санд төвлөрүүлнэ.

21<sup>2</sup>.3.1.18-37 хүртэлх хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундаанд 200 төгрөг;

21<sup>2</sup>.3.2.37, түүнээс дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундаанд 300 төгрөг.” гэж заасан.

Энэ хуулийн төслөөр тогтоож буй үүргийн хүрээнд аж ахуй нэгжид үүсэх шууд зардлыг тооцохдоо Монгол Улсад 2019 онд үйлдвэрлэсэн, импортолсон согтууруулах ундааны дүнг, энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн

этгээдийн тоонд хуваах замаар аж ахуйн нэгжид үүсэх зардлыг дундажлан тооцох болно.

Монгол улсад 2019 онд нийт 26.9 сая литр архи<sup>5</sup> үйлдвэрлэж, 1 851 286 литр архи болон бусад хатуулаг өндөртэй согтууруулах ундаа<sup>6</sup> импортолсон бөгөөд нийт 28 851 286 литр байна. Монгол Улсад 2019 оны байдлаар архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 26, архи, дарс импортлох тусгай зөвшөөрөлтэй 259, нийт 285 аж ахуйн нэгж<sup>7</sup> байна.

Хуулийн төсөлд 1 литр тутамд 18-37 хүртлэх хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундаанд 200 төгрөг, 37 ба түүнээс дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундаанд 300 төгрөгөөр тооцож санд төлөхөөр заасан. Үйлдвэрлэсэн, импортолсон согтууруулах ундааны хатуулагийг тодорхойлох боломжгүй тул дундажлаж  $300+200=500/2=250$  төгрөгөөр төлөх дүнг тооцов.

**Үүнээс тооцоолж үзэхэд:**

**28 851 286 литр х 250 төгрөг = 7 212 821 500 төгрөг**

**7 212 821 500 төгрөг / 285 хуулийн этгээд = 25 308 145.6 төгрөг.**

**НЭГ ХУУЛИЙН ЭТГЭЭД 1 ЖИЛД НИЙТ ҮЙЛДВЭРЛЭСЭН ЭСХҮЛ  
ИМПОРТЛОСОН СОГТУУРУУЛАХ УНДААНДАА ДУНДАЖААР 25 308 145.6  
ТӨГРӨГ ТӨЛӨХ**

Тооцоолж гаргасан зардлын дүн гэж ойлгож болохгүй. Учир нь хуулиар тогтоож буй үүргийн хүрээнд үүсэх зардал тодорхой хуулийн этгээдийн хувьд тэдгээрийн үйлдвэрлэсэн эсхүл импортолсон бүтээгдэхүүний тооноос шууд хамааралтай гэдгийг дурдая.

**ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ АЧААЛАЛ, ЗАРДЛЫН ТООЦОО**

Аргачлалын 3 дугаар зүйлд заасны дагуу иргэний зардал, ачааллыг тооцох

---

<sup>5</sup> Үндэсний статистикийн хорооны "Аж үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл" судалгаа, [https://www.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NSO\\_1100\\_013V1&AJ01\\_select\\_all=0&AJ01SingleSelect=\\_52\\_53&YearY\\_select\\_all=0&YearYSingleSelect=&viewtype=table](https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1100_013V1&AJ01_select_all=0&AJ01SingleSelect=_52_53&YearY_select_all=0&YearYSingleSelect=&viewtype=table)

<sup>6</sup> Гадаад худалдааны статистик мэдээлэл 2019он.

[https://customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info\\_full&cid=719&st=1](https://customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info_full&cid=719&st=1)

<sup>7</sup> Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны мэдээлэл.

ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

1. иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
3. тоон үзүүлэлтийг тооцох;
4. нийт дүнг тооцож гаргах;
5. хялбарчлах боломжийг шалгах.

Иргэний зардлыг тооцохдоо мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа (ачаалал)-г тооцно.

**Нэгдүгээр үе шатны хүрээнд:** Иргэний гүйцэтгэх үүргийг тодорхойлох шаардлагатай боловч Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийн

### **А.Согтууруулах ундаагаар үйлчлэх**

#### **А.Согтууруулах ундаагаар үйлчлэх**

<b>Хамаарах зүйл</b>	<b>Гүйцэтгэх арга хэмжээ</b>	<b>Үйл ажиллагаа, үе шат</b>	<b>Зарцуулах хугацаа</b>
27 дугаар зүйл	27.1.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтан нь согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтад хамрагдсан байна.	Сургалтын талаар мэдээлэл цуглуулах	30
	27.3.Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтыг аймаг, нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан нэгжээс магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд гүйцэтгэх бөгөөд төлбөрийн жишгийг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно. Сургалтын үргэлжлэх нийт хугацаа 5 цагаас ихгүй, 3 цагаас багагүй байна.	Сургалтад хамрагдах	240



Нийт			270

**А.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд 270 минутын зардал гарахаар**

### **САРЫН ЦАЛИН / АЖИЛЛАХ ХУГАЦАА = АЖЛЫН ХӨЛС**

Төрийн бус байгууллагын албан хаагчийн нэг сарын дундаж цалинг албан ёсоор дундажлан гаргасан мэдээлэл байхгүй байсан бөгөөд 2011 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Олон Улсын хөдөлмөрийн байгууллага, БНСУ-ын Засгийн газрын түншлэлийн хөтөлбөрөөс хамтран гаргасан Цалин хөлсний бүтцийн туршилтын судалгааны бодлогын шинжилгээний тайланд ТББ-ын удирдах ажилтны цалин хөлсийг өндөр, бусад ажилтнуудын цалин хөлсийг бага байна гэж үзсэн бөгөөд ерөнхийд нь хувьчлан тооцож нарийвчлан тодорхой гаргаагүй байна. Иймээс дунджаар албан хаагчийн сарын цалинг Засгийн газраас төрийн албан хаагчдын дундаж цалинг 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 1070.0 мянган төгрөг болсон гэж мэдээлсэн.

Харин ажиллах хугацааг тооцоходоо Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан ажлын цагаар тооцоолон долоо хоногт ажлын цаг нь 40 цаг, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг гэж тооцоход нийт нэр сард 10 560 минут ногдож байна.

$$1.070.000 / 22 \text{ ажлын өдөр} / 8 \text{ цаг} / 60 \text{ минут} = 101.3 \text{ төгрөг}$$

$$\text{АЖЛЫН ХӨЛС} * \text{ХУГАЦАА} = \text{ЗАРДАЛ}$$

$$\text{А.Согтууруулах ундаагаар үйлчлэх } 90.2 \text{ төг} * 270 \text{ мин} = 27\ 351 \text{ төгрөг}$$

**НЭГ ЭТГЭЭДЭД 27 351 ТӨГРӨГИЙН ЗАРДАЛ ГАРГАХААР БАЙНА.**

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
2. Тухайн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох;
3. Гарах зардлыг тооцох;
4. Бусад зардлыг тооцон нийт зардлыг нэгтгэн гарах.

**Нэгдүгээр үе шатны хүрээнд:** Хуулийн төслийн зохицуулалттай танилцаж, түүгээр үүрэг хүлээсэн байгууллага нэг бүрийг тодорхойлсон ба тэдгээрийн үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоог анхаарч үзсэн.

Гэхдээ байгууллагыг сонгохдоо тухайн ажил үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгодог болохыг анхаарсан.

### Нэгдүгээр үе шатны хүрээнд:

Хуулиар үүрэг хүлээж байгаа, хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий дараахь байгууллагууд байна:

1. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2. Мэргэжлийн хяналтын байгууллага
3. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар
4. Цагдаагийн байгууллага

Байгууллага	Хэсэг	Хэрэгжүүлэх арга хэмжээ
<b>Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</b>	5.2	5.2.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 5.1-д заасан зөвшөөрлийн хугацааг сунгаж, түдгэлзүүлж, сэргээнэ.
	5.5	5.5.Төсөл сонгон шалгаруулж тусгай зөвшөөрөл олгох журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.
	5.9	5.9.Энэ хуулийн 5.7-д заасан үйлдвэрлэлийн хүчин чадлыг тооцоолох аргачлал, заавал үйлдвэрлэх согтууруулах ундааны доод хэмжээг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно

	6.2	Энэ хуулийн 6.1.1-д заасан бичиг баримтын жагсаалтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.
	12.4	Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр зогсоох үндэслэл, журам болон энэ хуулийн 12.2-т заасан мэдэгдлийг хүргүүлэх, бүртгэх журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
	15.1	Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг эрүүл мэндийн болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.
	17.3	Энэ хуулийн 17.1, 17.2-т заасан тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлагыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
	26.5	Согтууруулах ундаагаар үйлчлэх үйлчилгээний стандартыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулна.
	27.4	Энэ хуулийн 27.2-т заасан сургалтын хөтөлбөрийг хууль зүйн болон хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
	40.1	Согтууруулах ундааны үйлдвэрлэлд тавих хяналтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч, татварын болон оюуны өмчийн байгууллага хэрэгжүүлнэ.
<b>Мэргэжлийн хяналтын байгууллага</b>	5.2	Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 5.1-д заасан зөвшөөрлийн хугацааг сунгаж, түдгэлзүүлж, сэргээнэ.
	5.3	Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг тухайн нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн

		нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн Захирагч олгож, сунгаж, түдгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно.
	15.3	Импортолж болох согтууруулах ундааны жагсаалтад орсон согтууруулах ундааны дээжийг мэргэжлийн хяналтын байгууллагаар урьдчилан шинжлүүлж, хилээр нэвтрүүлэх үед мэргэжлийн хяналтын болон гаалийн байгууллагын хяналт шалгалтад хамруулж баталгаажуулсан байна.
	40.1	Согтууруулах ундааны үйлдвэрлэлд тавих хяналтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч, татварын болон оюуны өмчийн байгууллага хэрэгжүүлнэ.
	40.2	Согтууруулах ундааны импорт, экспорт, реэкспортод тавих хяналтыг гаалийн болон мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.
<b>Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар</b>	5.3	Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг тухайн нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн Захирагч олгож, сунгаж, түдгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно.
	16.1	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 16.8-д заасан тусгай зөвшөөрлийн тоонд нийцүүлэн аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд чөлөөт бүсийн захирагч олгож, сунгаж, түдгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно.
	20.2	Энэ хуулийн 20.1-д заасан түр зөвшөөрлийг тухайн арга хэмжээг зохион байгуулагчтай гэрээ байгуулсан, энэ хуульд заасан согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.
	40.1	Согтууруулах ундааны үйлдвэрлэлд тавих хяналтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч, татварын болон оюуны өмчийн байгууллага хэрэгжүүлнэ.
<b>Цагдаагийн байгууллага</b>	40.3.2	Согтууруулах ундаа худалдах, хэрэглэх, түүгээр үйлчлэх талаар тогтоосон журмын биелэлтэд дараахь байгууллага, албан тушаалтан энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаар олгосон эрх хэмжээний дотор хяналт тавина: 40.3.2.цагдаагийн байгууллага; цагдаагийн байгууллага;

Аргачлалын 4.3.3-т заасны дагуу ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулж тооцох тул үнэлгээнд тохиолдлын тоог тогтоох боломжгүй ажил буюу хуулийн хэрэгжилтэд хяналт тавих түүнчлэн төрийн захиргааны төв байгууллагын бодлого боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцооноос хасаж дараахь байдлаар гүйцэтгэх ажил үүрэг,

байгууллагыг тодорхойлоо.

Байгууллага	Хэс	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Стандарт үйл ажиллагаа
Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	5.2	Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 5.1-д заасан зөвшөөрлийн хугацааг сунгаж, түдгэлзүүлж, сэргээнэ.	Бичиг баримтыг хүлээн авах
			Бичиг баримтыг нягтлах
			Шийдвэр гаргах
	5.5	Төсөл сонгон шалгаруулах журам боловсруулах, Засгийн газарт танилцуулах	Мэдээлэл цуглуулах
			Төсөл боловсруулж, батлуулах
	5.9	Энэ хуулийн 5.7-д заасан үйлдвэрлэлийн хүчин чадлыг тооцоолох аргачлал, заавал үйлдвэрлэх согтууруулах ундааны доод хэмжээг тогтооно.	Мэдээлэл цуглуулах
			Төсөл боловсруулж, батлуулах
	6.2	Энэ хуулийн 6.1.1-д заасан бичиг баримтын жагсаалтыг тогтоох.	Мэдээлэл цуглуулах
			Төсөл боловсруулж, батлуулах
	12.4	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр зогсоох үндэслэл, журам болон энэ хуулийн 12.2-т заасан мэдэгдлийг хүргүүлэх, бүртгэх журмыг батлах	Мэдээлэл цуглуулах
Төсөл боловсруулж, батлуулах			
15.1	Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг эрүүл мэндийн болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.	Мэдээлэл цуглуулах	
		Төсөл боловсруулах, харилцан мэдээлэл солилцох	
		Төслийг эцэслэн боловсруулах, батлуулах	
17.3	Энэ хуулийн 17.1, 17.2-т заасан тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлагыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална	Мэдээлэл цуглуулах	

			Төсөл боловсруулах, харилцан мэдээлэл солилцох
			Төслийг эцэслэн боловсруулах, батлуулах
	26.5	Согтууруулах ундаагаар үйлчлэх үйлчилгээний стандартыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулна	Мэдээлэл цуглуулах Төсөл боловсруулж, сонирхогч этгээдүүдийн саналыг авах, зөвшилцөх, Төслийг эцэслэн боловсруулж батлуулах
	27.4	Энэ хуулийн 27.2-т заасан сургалтын хөтөлбөрийг хууль зүйн болон хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Мэдээлэл цуглуулах Төсөл боловсруулж, сонирхогч этгээдүүдийн саналыг авах, зөвшилцөх, Төслийг эцэслэн боловсруулж батлуулах
<b>Мэргэжлийн хяналтын байгууллага</b>	5.2	тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, дуусгавар болгох талаар санал дүгнэлт гаргах	Бичиг баримт хүлээн авах Шалгалт хийх, бичиг баримтыг нягтлан шалгах, шаардлагатай тайлбар мэдээлэл цуглуулах Бичиг баримтыг нягтлах, санал дүгнэлт боловсруулах
	15.3	Импортолж согтууруулах ундааны дээжийг урьдчилан шинжлэх, хилээр нэвтрүүлэх үед шалгалтад хамруулах, баталгаажуулах	Бичиг баримт хүлээн авах Шалгалт хийх, бичиг баримтыг нягтлан шалгах, шаардлагатай тайлбар мэдээлэл цуглуулах Шийдвэр гаргах
<b>Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар</b>	5.3	Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимиин архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох.	Бичиг баримт хүлээн авах Шалгалт хийх, бичиг баримтыг нягтлан шалгах, шаардлагатай тайлбар мэдээлэл цуглуулах Бичиг баримтыг нягтлах, санал дүгнэлт боловсруулах, шийдвэр гаргах
	16.1	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, дуусгавар болгох, хүчингүй болгох	Бичиг баримт хүлээн авах Шалгалт хийх, бичиг баримтыг нягтлан шалгах, шаардлагатай тайлбар мэдээлэл цуглуулах Бичиг баримтыг нягтлах, санал дүгнэлт боловсруулах, шийдвэр гаргах

**Хоёрдугаар үе шатны хүрээнд:** Дээрх үүргийг хэрэгжүүлэх хүний нөөцийг тодорхойлохын тулд дараах алхмыг гүйцэтгэнэ.

**1. тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа**

2.жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог /цаашид “**тохиолдлын тоо**” гэх/,

3.шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргалаа.

Дээр дурдсан үүргийг гүйцэтгэхэд хийх үйлдэл нэг бүрийг тогтоож, түүнд зарцуулах хугацааг минутаар тооцож тус байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн гаргасан.

Байгууллага	Хэсэг	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ
	5.2	Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 5.1-д заасан зөвшөөрлийн хугацааг сунгаж, түдгэлзүүлж, сэргээнэ	Бичиг баримт хүлээн авах	10	18	180
			Бичиг баримтыг нягтлах	480	3	1440
			Шийдвэр гаргах	120	3	360
	5.5	Төсөл сонгон шалгаруулах журам боловсруулах, Засгийн газарт танилцуулах	Мэдээлэл цуглуулах	480	1	480
			Төсөл боловсруулж, батлуулах	240	1	240
	5.9	5.9.Энэ хуулийн 5.7-д заасан үйлдвэрлэлийн хүчин чадлыг тооцоолох аргачлал, заавал үйлдвэрлэх согтууруулах ундааны доод хэмжээг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно	Мэдээлэл цуглуулах	480	1	480
			Төсөл боловсруулж, батлуулах	240	1	240
	6.2	Энэ хуулийн 6.1.1-д заасан бичиг баримтын жагсаалтыг тогтоох.	Мэдээлэл цуглуулах	480	1	480
			Төсөл боловсруулж, батлуулах	240	1	240
	12.4	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр зогсоох үндэслэл, журам болон энэ хуулийн 12.2-т заасан мэдэгдлийг хүргүүлэх, бүртгэх журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална	Мэдээлэл цуглуулах	480	1	480
			Төсөл боловсруулж, батлуулах	480	1	480
	15.1	Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг эрүүл мэндийн болон	Мэдээлэл цуглуулах	480	25	12000
			Төсөл боловсруулж, батлуулах	480	25	12000

		хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.	Төслийг эцэслэн боловсруулах, батлуулах	240	25	6000
17.3		Энэ хуулийн 17.1, 17.2-т заасан тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлагыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Мэдээлэл цуглуулах	480	1	480
			Төсөл боловсруулж, батлуулах	240	1	240
			Төслийг эцэслэн боловсруулах, батлуулах	240	1	240
26.5		Согтууруулах ундаагаар үйлчлэх үйлчилгээний стандартыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулна	Мэдээлэл цуглуулах	480	1	480
			Төслийг боловсруулж сонирхогч этгээдүүдийн саналыг авах			
			Төслийг эцэслэн боловсруулах, батлуулах	120	1	120
27.4		Энэ хуулийн 27.2-т заасан сургалтын хөтөлбөрийг хууль зүйн болон хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална	Мэдээлэл цуглуулах	480	1	480
			Төсөл боловсруулж, батлуулах	240	1	240
			Төслийг эцэслэн боловсруулах, батлуулах	120	1	120
5.2		Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 5.1-д заасан зөвшөөрлийн хугацааг сунгаж, түдгэлзүүлж, сэргээнэ	Бичиг баримт хүлээн авах	10	18	180
			Бичиг баримтыг нягтлах, шаардлагатай тайлбар мэдээлэл цуглуулах	480	18	8640
			Шийдвэр гаргах	240	18	4320
15.3		Импортолж согтууруулах ундааны дээжииг урьдчилан шинжлэх, хилээр нэвтрүүлэх үед шалгалтад хамруулах, баталгаажуулах	Бичиг баримт хүлээн авах	10	500	5000
			Шалгалт хийх, бичиг баримтыг нягтлан шалгах, шаардлагатай тайлбар мэдээлэл цуглуулах	240	500	120000
			Шийдвэр гаргах	60	500	30000
5.3		Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимиин архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх,	Бичиг баримт хүлээн авах	10	5	50
			Шалгалт хийх, бичиг баримтыг нягтлан шалгах,	480	5	2400



	хүчингүй болгох	шаардлагатай тайлбар мэдээлэл цуглуулах			
		Шийдвэр гаргах	240	5	1200
16.1	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, дуусгавар болгох, хүчингүй болгох	Бичиг баримт хүлээн авах	10	2000	20000
		Шалгалт хийх, бичиг баримтыг нягтлан шалгах, шаардлагатай тайлбар мэдээлэл цуглуулах	480	2000	960000
		Шийдвэр гаргах	120	2000	240000

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэгжилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 20 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг 1

ажлын цаг = 60 минут

Нэг жилд 200 ажлын өдөр буюу /200\*8/ 1600 ажлын цаг буюу 96 000 минут байна.

Байгууллага	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг	Нэмэгдэж буй ажлын ачаалал /орон тоо/
Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	47 490	96 000	0.49
Мэргэжлийн хяналтын байгууллага	170 330	96 000	1.7*
Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар	1 223 650	96 000	12.7*

\*Мэргэжлийн хяналтын байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын хувьд үүсэх ачаалал нь нийт 21 аймаг, болон нийслэлийн хэмжээний байгууллагуудад нийтэд нь үүсэх зардал болно.

**Гуравдугаар үе шатны хүрээнд:** Зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн зардлын мэдээллийн үндсэн дээр гаргадаг бөгөөд ажиллах шаардлагатай хүний нөөцтэй тэдгээр зардлын оногдох хэсгүүдийн нийлбэрээр уг зардлыг тооцох боломжтой боловч **хүний нөөцийн зардал** буюу алба хаагчийн авч болох цалин, нэмэгдэл, тусламж, төрөөс даадаг бусад зардал, болон тухайн ажлын байртай холбоотой гарах бусад зардлыг нэгдсэн жишиг, норматив байхгүй байна.

Гэсэн хэдий боловч төрийн албан хаагчийн цалингийн зэрэглэл, шатлал болон цалин хөлсний нэмэгдэл, нийгмийн даатгалын шимтгэл гэх зэрэг зардлуудыг тооцон нэгтгэж дунджаар нэг ажилтны зардалд нэг жилд 10,5 сая төгрөг зарцуулдаг гэж тооцоолсон болно.

Байгууллага	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/	Цалингийн зардал	Нийт хүний нөөцийн зардал
Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	0.49	10, 500 000	5 145 000
Мэргэжлийн хяналтын байгууллага	1.7	10 500 000	17 850 000
Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар	12.7	10 500 000	133 350 000

**Материаллаг зардлын хувьд** Монгол Улсын хэмжээнд нэг төрийн алба хаагчид ногдох материаллаг зардлын жишиг байхгүй тул тооцооллыг дуусгав.

Шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээн дээр үндэслэн тухайлсан байгууллагын хувьд зардлыг тооцон гаргах боломжтой юм.

**Дөрөвдүгээр үе шатны хүрээнд:** Нийт дүнг тооцоолох бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргана. Шаардлагатай албан хаагчийн хэрэгцээ өмнөх үе шатуудад тодорхой болсон тул энэ үе шатанд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайлсан төрийн байгууллагын нэг төрийн албан хаагчид оногдох материаллаг зардлыг хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын зүгээс хийгдэх ажиллагааг гүйцэтгэх шаардлагатай хүний нөөцөөр үржүүлэх замаар гаргах боломжтой юм. Нэг албан хаагчид ногдох хүний нөөцийн болон материаллаг зардлын тогтоосон жишиг одоогоор байхгүй байгаа тул үүнийг ерөнхий байдлаар тооцоолох боломжгүй байна.

**Тавдугаар үе шатны хүрээнд:** Хувилбарыг нягтлан хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл төсвийн зардлыг багасгах боломж бий эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг тогтооно.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд төсвийн зардлыг багасгах, эдийн засагт дарамт багатай зохицуулах өөр боломж нөхцөл байгаа эсэхийг тогтоох шаардлагатай хэдий ч үнэлгээ хийсэн хуулийн төслийн хувьд төсөвт үзүүлэх ачаалал харьцангуй бага буюу одоогоос мэдэгдэхүйц байдлаар өөрчлөлт орох зүйл тогтоогдоогүй байна.